



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/650

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сайхан суманд Төрийн албан хаагчдын орон сууц барьж, ашиглалтад оруулах ажлын үргэлжлэл” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Баганадант” ХХК-тай 109 520 550 (нэг зуун есөн сая таван зуун хорин мянга таван зуун тавин) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д олгосугай

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Баганадант” ХХК-ийн захирал (А.Нямжаргал)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтээр санхүүжүүлэхийг Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

5. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6324010899

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 01-ны өдрийн
Х/Б Дугаар захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Баясгалан
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Баясгалан
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Д.Баясгалан
4	Магадлашгүй ажил	1 814 908	Ү.Бямбасүрэн
5	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	907 454	Ү.Бямбасүрэн
6	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	5 000 000	Ү.Бямбасүрэн
7	Нормчлолын сан	163 342	Ү.Бямбасүрэн
8	Захиалагчийн техник хяналтын зардал	1 814 908	Ү.Бямбасүрэн
9	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн